

**ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН АВЛИГЫН ЭСРЭГ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Төсөв, зардал (мян.төг)	Хугацаа	Хариуцах нэгж, албан тушаалтан
1	2	3	4	5	6
Нэг.Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх					
1.1	Байгууллагын ил тод нээлттэй байдлыг хангах хүрээнд авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, инфо, өргөдөл, гомдлын мэдээг байгууллагын www.bpo.gov.mn цахим хаягт байршуулж, олон нийтэд хүргэх	-Авлигын эсрэг хууль тогтоомжоор төрийн байгууллагад хүлээлгэсэн үүрэг хэрэгжих; -Иргэд, алба хаагчид мэдээлэлтэй болсон байх	Зардал шаардахгүй	I-XII сар	Хууль, эрх зүйн хэлтэс,
1.2	АТГ-аас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас, нийгмийн сүлжээ, дотоод сүлжээ (фэйсбүүк, твиттер, youtube) дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр алба хаагч, олон нийтэд хүргэх	-Тогтмол шинэчлэн тогтвортой байршуулсан байх; -Баримтжуулсан байх; -Үр дүнг тооцож, тайлагнасан байх (түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо); -Хилийн цэргийн анги, тусгай салбарыг нэгэн зэрэг хамруулж, үр дүнг нэгтгэн тайлагнаж, хэвших	Зардал шаардахгүй	I-XII сар	Хууль, эрх зүйн хэлтэс, Хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах алба
1.3	Хилийн цэргийн анги, салбарын онцлогт тохируулан иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг, авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах	-Өдөрлөгт оролцсон иргэдээс байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой санал хүсэлт авч, түүнд үндэслэн арга хэмжээг хэрэгжүүлсэн байх; -Авлигатай тэмцэх газраас өрнүүлж буй аян, уриалгатай уялдсан байх; -Үр дүнг тооцсон байх.	Зардал шаардахгүй	Тайлант хугацаанд	Хууль, эрх зүйн хэлтэс Сэтгэл зүйн хангалтын хэлтэс
1.4	Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбарыг тогтмол ажиллагаатай байлгах, АТГ-аас ирүүлсэн материалыг байршуулах	-Мэдээллийг Авлигатай тэмцэх газраас буюу баталгаат эх сурвалжаас авсан байх; -Байгууллагын эрх хэмжээний хүрээнд иргэд, олон нийт рүү	Зардал шаардахгүй	I-XII сар	Хууль, эрх зүйн хэлтэс

		чиглэсэн хэвлэмэл материалд оруулсан байх; -Үр дүнг нэгтгэн тайлагнасан байх; -Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших			
1.5	Хил хамгаалах байгууллагын үйл ажиллагаанд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий 2-оос доошгүй видео контент бүтээж, олон нийтэд хүргэсэн байх	-2-оос доошгүй сурталчилгааны материал боловсруулсан байх; -Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх; -Авлигын мэдээлэх 110 дугаарын утсыг сурталчилсан байх; -Олон нийтэд түгээсэн байх	Зардал шаардахгүй	Тайлант хугацаанд	Хууль, эрх зүйн хэлтэс Сэтгэл зүйн хангалтын хэлтэс, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба
1.6	Алба хаагчдын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг авч, тайланг хүргүүлэх	Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хүлээн авч, Авлигатай тэмцэх газарт тайлагнасан байх	Үйл ажиллагааны зардлаас	I-XII cap	Хууль, эрх зүйн хэлтэс
Хоёр.Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах					
2.1	Авлигын эсрэг сургалтад шинээр томилогдсон албан хаагчдыг хамруулах, давтан сургах	-Шинэ томилогдсон албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад бүрэн хамруулсан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх	Зардал шаардахгүй	I-XII cap	Удирдлага, Хууль, эрх зүйн хэлтэс,
2.2	Тухайн байгууллагын хариуцдаг, шууд хамаардаг, хамтран ажилладаг (тухайлбал, тусгай зөвшөөрөл эзэмшигч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, хамтран ажилладаг бизнесийн байгууллага, үйлчилгээ авдаг хуулийн этгээд, иргэн, хяналт, оролцоо хэрэгжүүлдэг ТББ г.м) байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх сурталчлах арга хэмжээг зохион байгуулах.	-Өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулсан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх	Зардал шаардахгүй	I-XII cap	Хууль, эрх зүйн хэлтэс, Хилийн хэлтэс, Хилийн цэргийн тусгай архив

3.3	Бие бүрэлдэхүүний онол, эрх зүйн сургалтын хөтөлбөрт Авлигын эсрэг хууль тогтоомжийн талаар тусган, сургалт мэдээлэл, яриа таниулга хийх	Алба хаагчдын зүгээс хууль тогтоомжийг судалж мэдсэн, үйл ажиллагаандаа мөрдөж хэвшсэн байх	Зардал шаардахгүй	I-XII cap	Хууль, эрх зүйн хэлтэс, хилийн цэргийн анги, тусгай салбар
Гурав.Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох					
3.1	Хил хамгаалах байгууллагаас Төрийн байгууллага, хувийн хэвшил, иргэн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх	-Байгуулсан бүх гэрээнд авлигаас ангид байх асуудлыг тусгасан байх; -Авлигыг мэдээлэх үүргийг тусгасан байх; -Гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг оруулах; -Хэрэгжилтийн ач холбогдлыг үнэлж, дүгнэсэн байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх	Зардал шаардахгүй	I-XII cap	Хууль, эрх зүйн хэлтэс, Төлөвлөлт хангалтын хэлтэс, Үйлчилгээ, аж ахуйн алба
3.2	“Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх	-Олон нийтийн хяналтад хамруулах чиглэлийг тодорхойлсон байх; -Сургалт, мэдээлэл авсан байх; -Хяналтын чиг үүргийг гүйцэтгүүлэх, тайлан зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлсэн байх.	Зардал шаардахгүй	I-XII cap	Хууль, эрх зүйн хэлтэс
3.3	Төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах	-2024 онд төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар иргэд, олон нийтэд тогтмол ойлгомжтой байдлаар тогтмол мэдээлэх; -Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой иргэд, олон нийтийн саналыг авч, холбогдох арга хэмжээг авах; -Иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлэх	Зардал шаардахгүй	I-XII cap	Хууль, эрх зүйн хэлтэс, Санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтэс
Дөрөв.Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах					
4.1.	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг	-Үйл ажиллагаанд эрсдэлийг	Үйл	I-XII cap	Хууль, эрх зүйн

	бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх (үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м) хилийн цэргийн анги, тусгай салбарт тоон гарын үсэг нэвтрүүлэх	тодорхойлж, урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг тооцсон байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх; -Хэрэглэгчийн үнэлгээнээс гарсан зөвлөмжийг хэрэгжүүлж, тайланг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргэх	ажиллагааны зардлаас		хэлтэс, Мэдээллийн технологийн хэлтэс, Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс
4.2	Хил хамгаалах байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлж хэвших	-Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой гомдол, мэдээллийн судалгааг тогтмол гаргаж, тайлагнах; -Хуулийн хүрээнд шуурхай, бодитой шийдвэрлэж хэвших; -Иргэд, олон нийтээс байгууллагын үйл ажиллагаа, хүнд суртал чирэгдэл, холбоотой гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны зардлаас	I-XII cap	Удирдлага, Хууль, эрх зүйн хэлтэс, Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс
4.3	Үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах.	-Бодитой үр дүнг тооцсон байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх	Үйл ажиллагааны зардлаас	I-XII cap	Хууль, эрх зүйн хэлтэс, Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс
4.4	Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн мэдэгдэл, зөвлөмжид тусгагдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх	-Мэдэгдэл, зөвлөмжид тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлж, хариуг хуулийн хугацаанд хүргүүлсэн байх	Зардал шаардахгүй	I-XII cap	Хууль, эрх зүйн хэлтэс
4.5	Тендерийг хууль тогтоомжийн хүрээнд зарлах, зохион байгуулах	-Хууль тогтоомж хэрэгжиж, шударга байдал хангагдах	Урсгал зардлаас	I-III cap	Төлөвлөлт хангалтын хэлтэс
Тав.Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх					
5.1	Хил хамгаалах байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны 2024 оны тайланг	-Төлөвлөсөн арга хэмжээг зураг, тоон үзүүлэлт, дүрс бичлэгээр	Зардал шаардахгүй	VI/15-ны дотор	Хууль, эрх зүйн хэлтэс

	Авлигатай тэмцэх газарт газрын www.khutulbur.iaac.mn цахим системд тайлагнах	баримтжуулан, дүгнэх хуудасны дагуу дүгнэн хавсаргаж, тайланг хугацаанд тайлагнасан байх		XII/15-ны дотор	
5.2	Хил хамгаалах байгууллагын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2024 оны I улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр бие бүрэлдэхүүнд танилцуулах	-Танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан байх; -Албан хаагчдаас гаргасан санал санаачилгыг хэлэлцсэн байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх	Үйл ажиллагааны зардлаас	I, II, VI улиралд	Хууль, эрх зүйн хэлтэс
5.3	Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн албан тушаалтнуудын Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газраар хянуулах	-Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилт хангагдах	Зардал шаардахгүй	I-XII сар	Хууль, эрх зүйн хэлтэс
5.4	Авлигатай тэмцэх газраас дүрэм журам, ёс зүйн дүрмийн төсөлд өгсөн санал, зөвлөмжийг тусгасан байдал	-Санал тусгасан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх	Зардал шаардахгүй	I-XII сар	Хууль, эрх зүйн хэлтэс
5.5	Удирдлага салбар, нэгж, байгууллагын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр санаачлан хийх ажил, арга хэмжээг нэмж төлөвлөн, тайлагнах	-Төлөвлөгөөг баталж, олон нийт танилцах боломжоор хангасан байх; -www.khutulbur.iaac.mn цахим санд нэмж оруулсан байх, -Тайлагнасан байх	Зардал шаардахгүй	I-XII сар	Хууль, эрх зүйн хэлтэс
5.6	Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран “Эх орны манаа” сониноор дамжуулан нийтлэл уншигчдад хүргэх	-Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, эсрэг сурталчилгааны шторк, нийтлэлийг алба хаагч, олон нийтэд хүргэх	Зардал шаардахгүй	I-XII сар	Хууль, эрх зүйн хэлтэс
5.7	Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн санал, зөвлөмжийг тусган Хүний нөөцийн дүрэм, Ёс зүйн дүрэм, холбогдох журмуудыг байгууллагын цахим хуудсанд байршуулах	-Хууль тогтоомж хэрэгжсэн байх: -Хүний нөөцийн ил тод байдал хангагдсан байх	Зардал шаардахгүй	Тухай бүр	Хууль, эрх зүйн хэлтэс Хүний нөөцийн бодлого зохицуулалтын газар
5.8	Хүний нөөцийн бодлогын ил тод байдлыг хангах, тусгай мэргэжлийн сул орон тоонд хуульд заасан үндэслэл, журмын дагуу сонгон шалгаруулалт явуулах, нөлөөллөөс	-Төрийн албаны тухай хууль хэрэгжсэн байх	Зардал шаардахгүй	I-XII сар	Хууль, эрх зүйн хэлтэс Хүний нөөцийн бодлого

	ангид, мэдлэг, боловсролд суурилсан чадахуйн зарчмыг хэрэгжүүлэх				зохицуулалтын газар
5.9	Тендерийн үнэлгээний хорооны комиссын гишүүд, өмч хамгаалах байнгын зөвлөлийн гишүүдээр ашиг сонирхлын зөрчилгүй эсэхээ илэрхийлсэн мэдэгдэл гаргуулах, тайлбар мэдэгдлийг https://meduuleg.iaac.mn цахим системд байрлуулж, хуулийн хэрэгжилтийг хангуулах	Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж ажилласан байх	Зардал шаардахгүй	I-XII сар	Төлөвлөлт хангалтын хэлтэс ЭБАТ-ууд
5.10	Иргэн, байгууллагаас ирсэн өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээллийг хүлээн авч, хянан шийдвэрлэх	-Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилт хангагдах; -Иргэдийн эрх ашиг хамгаалагдах; -Тухайн жилд иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар дүн мэдээг тайлагнах.	Зардал шаардахгүй	I-XII сар	Удирдлага, Хилийн цэргийн анги, тусгай салбарын захирагч нар, Хууль, эрх зүйн хэлтэс
5.11	Шаардлагатай тохиолдолд гомдол, мэдээллийн мөрөөр албаны шалгалт явуулах, тайлан мэдээг тогтоосон хугацаанд холбогдох байгууллагуудад хүргүүлэх				
5.12	Шилэн дансны болон Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг хэрэгжүүлж, нууцад хамаарахгүй мэдээ мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, байршуулах	-Иргэний мэдээлэл авах эрх, байгууллагын ил тод нээлттэй байдал хангагдсан байх.	Зардал шаардахгүй	I-XII сар	Санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтэс
5.13	Санхүүгийн үйл ажиллагаанд Үндэсний аудитын газраар тайлангийн аудит хийлгэж, нууцад хамааралгүй дүгнэлт, зөвлөмжийг нийтэд мэдээлэх	-Төсвийн тухай хуулийн хэрэгжилт хангагдсан байх	Зардал шаардахгүй	II-III сар	Санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтэс
5.14	Дотоод хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөг гарган, хэрэгжүүлэх, хилийн цэргийн анги, төрийн өмчит улсын үйлдвэрийн газар, Санхүү, хөрөнгө оруулалтын газар, Хөрөнгө оруулалт, барилгын албаны үйл ажиллагаанд дотоод аудит хийх	-Шударга, нээлттэй, ил тод байдал хангагдах; -Байгууллагын үйл ажиллагааны үр дүнд эерэг нөлөө үзүүлсэн байх	Үйл ажиллагааны хүрээнд	Тухай бүр	Санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтэс
			Урсгал зардлаас	I-XII сар	
5.15	Хяналт шалгалт явуулсан дүнгийн тухай акт, илтгэх хуудсыг ХХЕГ-ын даргын зөвлөлд танилцуулж, илэрсэн зөрчил дутагдлыг				

	арилгах арга хэмжээ авах, дүнг бие бүрэлдэхүүнд мэдээлэх				
Зургаа.Бусад					
6.1	Нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон актыг байгууллагын цахим хуудсанд байршуулж, олон нийтэд хүргэх	-Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, "Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг хангах тухай" тогтоолын холбогдох заалтууд хэрэгжсэн байх	Зардал шаардахгүй	I-XII cap	Газар, хэлтсийн дарга нар, Хууль, эрх зүйн хэлтэс
6.2	Хил хамгаалах байгууллагаас олгож буй зөвшөөрөл, лавлагаа авахад шаардлагатай материалыг цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулж, иргэдэд шуурхай үйлчлэх	-Байгууллагын ил тод, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний шуурхай байдал хангагдах	Зардал шаардахгүй	I-XII cap	Хууль, эрх зүйн хэлтэс, Хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах алба
6.3	Хил хамгаалах байгууллага, хилчдийн үйл ажиллагааг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, иргэдэд чиглэсэн эрх зүйн сурталчилгааг төлөвлөн хэрэгжүүлэх	-Төрийн үйлчилгээний чанар сайжирч, хүнд суртал чирэгдэл багасна, албаны нэр хүндэд эерэг нөлөө үзүүлэх		I-XII cap	Сэтгэл зүйн хангалтын хэлтэс, Хууль, эрх зүйн хэлтэс
6.4	Хил хамгаалах байгууллагын алба, үйл ажиллагаатай хүүхэд, залуучуудыг танилцуулах	-Улсын хил хамгаалах алба, үйл ажиллагааны талаар мэдлэг, цэрэг, эх оронч төлөвшил олгох	Зардал шаардахгүй	I-XII cap	Хилийн цэргийн анги, тусгай салбарын захирагч нар, Хилийн түүхийн музей
6.5	Хилийн цэргийн анги, тусгай салбарын мэдүүлэг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудыг удирдлагаар хангах	-Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах	Зардал шаардахгүй	I-XII cap	Хууль, эрх зүйн хэлтэс

ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗАР